



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 12 өдөр


Дугаар А/518

Ховд

Урьдчилгаа санхүүжилт олгож тооцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны "Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай" 7/02 дугаар тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн халаалтад холбогдсон зарим сумдын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд дулаан түгээлтийн "Мирай кэнсэцү" ХХК-д халаалтын зардлын урьдчилгаа санхүүжилтэд 257,249,351 төгрөг (хоёр зуун тавин долоон сая хоёр зуун дөчин есөн мянга гурван зуун тавин нэг)-ийг буцаан төвлөрүүлэх нөхцөлтэйгээр олгосугай.
2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 257,249,351 төгрөг (хоёр зуун тавин долоон сая хоёр зуун дөчин есөн мянга гурван зуун тавин нэг)-ийг аймгийн Хөшөөт хөгжил санд 2022 онд төвлөрсөн орлогоос санхүүжүүлэхийг аймгийн Хөшөөт хөгжил сангийн захирал (Т.Мягмардорж)-д зөвшөөрсүгэй.
3. Урьдчилан олгосон санхүүжилтийг аймгийн Засаг дарга дансанд 2022 онд батлагдсан төсвөөс буцаан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д даалгасугай.
4. Байгууллагуудад дулаан түгээх ажиллагааны 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг "Мирай кэнсэцү" компанийн захирал (Б.Цэнд-Аюуш)-д зөвлөсүгэй.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2660
Zah A/518 Bo